



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 531

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1.5 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 1, 2, 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 191 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 8.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 2023/ШЦТ/17 дугаар шийтгэх тогтоолоор хураагдаж, улсын төсөвт шилжүүлэхээр шийдвэрлэсэн, хөрөнгө, даатгалын хохирлын үнэлгээний "Ашид билгүүн" ХХК 79,000,000.00 (далан есөн сая) төгрөгөөр үнэлсэн, хавсралтад заасан хөрөнгө (автомашин)-ийг төрийн өмчид хүлээн авч, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Энхтуяа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа О.Амарсанаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчдийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ
132006339

28-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 11 дугаар сарын 24-ны өдрийн
53 дүгээр тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬА НИЙСЛЭЛИЙН ШҮҮХИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ

| Д/д | Хөрөнгийн нэр, марк | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэг бүрийн үнэ (төгрөг) | Нийт үнэ (төгрөг) |
|----------|---|-------------|------------|-------------------------|-----------------------------------|
| 1 | Суудлын автомашин, Лексус RX450h, 10-86 УАХ (арал-гул162405273) | ш | 1 | 79,000,000.00 | 79,000,000.00 |
| Нийт дүн | | | | | 79,000,000.00 (далан есөн сая) |